

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 02 дүгээр сарын 09

№02

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Эрдмийн зөвлөлийн 1-203 тоот танхимд 14:00 цагт эхэлж, 18:45 дуусав. Хуралд 16 гишүүн оролцохоос 16 гишүүн буюу 100% -ийн ирцтэй ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдав.

Хуралд: Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Оюунтунгалаг, Л.Амартүвшин, Б.Батдэмбэрэл, А.Болормаа, Я.Батцэцэг, Ш.Цоож, Р.Мядагмаа, Г.Батцэцэг, Ч.Улам-Оргил, Д.Ариунболор, Д.Дулмаа, Г.Ариунтөгс нар оролцов.

Хэлэлцсэн асуудал:

1. ШУТИС-ийн магистрын хөтөлбөрт "Эргэцүүлэлт сэтгэлгээ" хичээлийг оруулах санал, /асуулт, санал/
2. "Орон судлал" сургалтын хөтөлбөрөөр Турк улсын Измир Катип Челеби их сургуультай хамтарсан (1+1,5) хөтөлбөр хэрэгжүүлэх (дахин хэлэлцүүлэх) /асуулт, санал/
БүХС-ийн ХУС-ын эрхлэгч Ц.Батцэрэн
3. "Гагнуурын технологи инженер" хөтөлбөр нээх тухай, /асуулт, санал/
МехТС-ийн МҮС-ын дэд профессор О.Галаа
4. ШУТИС-ийн хөтөлбөрүүдэд S.FL111, S.FL112- Герман хэл 1, 2 /Сонгон хичээл/-ийг нэмж оруулах асуудлыг дахин хэлэлцүүлэх, /асуулт, санал/
ГХС-ийн Сургалт, чанарын албаны дарга А.Болормаа
5. ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт Япон хэл 2 /N4/, Солонгос хэл 2, Хятад хэл 2 хичээлийг судлах боломжийг хангах асуудал, /асуулт, санал/
ГХС-ийн Сургалт, чанарын албаны дарга А.Болормаа
6. ХЕХ-ны 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улиралд хийх ажлын төлөвлөгөө батлах, /асуулт, санал/
Сургалт, цахим шилжилтийн газрын захирал Н.Эрдэнэхүү
7. ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл
 - Сургалтын хөтөлбөр боловсруулах жишиг загвар /бакалавр, магистр, доктор/
 - Хичээлийн хөтөлбөрийн жишиг загвар /нэгж/
 - Сургалтын хөтөлбөрийн журам боловсруулах асуудал, үндсэн зарчим танилцуулах /асуулт, санал/Сургалт, цахим шилжилтийн газрын захирал Н.Эрдэнэхүү
Ахисан түвшний хөтөлбөрийн албаны дарга Д.Оюунцэцэг


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

№	Хэлэлцүүлсэн асуудал	Санал, зөвлөмж	ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:
1.	ШУТИС-ийн магистрын хөтөлбөрт "Эргэцүүлэлт сэтгэлгээ" хичээлийг оруулах санал, /асуулт, санал/	Сонгон хичээл байх нь тохиромжтой Сурах бичгийг тодорхой болгох Хичээлийн агуулгыг сайжруулах	АТХА-аас дэмжиж байгааг харгалзан, хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд ШУТИС-ийн бакалавр, магистр, докторын түвшиний хөтөлбөрт хичээлийн залгамж холбоог ханган, сонгон судлах хичээлээр оруулахыг дэмжлээ.
2.	"Орон судлал" сургалтын хөтөлбөрөөр Турк улсын Измир Катип Челеби их сургуультай хамтарсан (1+1,5) хөтөлбөр хэрэгжүүлэх (дахин хэлэлцүүлэх) /асуулт, санал/	Үндсэн хөтөлбөр хэрэгжүүлэх гэж тодорхойлох ШУТИС-ийн журамд нийцүүлэх (ерөнхий суурь хичээл, нийт кредит... гэх мэт) Элсэгчдэд тавигдах шаардлагыг тодорхой болгох Судлаач, мэргэжлийн магистр аль нь байхыг тодруулах Хөтөлбөрийн боловсруулалт дээр дахин ажиллах	ХЕХ-ны гишүүдийн санал зөвлөмжийг тусган, сайжруулаад "Орон судлал" үндсэн хөтөлбөр хэрэгжүүлэх саналаар УМИ-д хүсэлт хүргүүлэхийг дэмжлээ. Хөтөлбөр боловсруулах шинэчилсэн зааврын (шалгуур, шаардлага) дагуу сайжруулалтаа хийж, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх саналын хамт дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.
3.	"Гагнуурын технологи инженер" хөтөлбөр нээх тухай, /асуулт, санал/	Одоогоор хөтөлбөрт мэргэжлийн чиглэл байгаа хэдий ч элсэлттгүй байгаад анхаарах (цаашид хөтөлбөр байх боломжтой) Мэргэжлийн онцлогийг харгалзан дадлагын хичээлийн цагийг нэмэгдүүлэх Мэргэшлийн нэршлийг эргэн харах Барилга, байгууламжийн гагнуурын талаар агуулга нэмж оруулах	Металлурги, металлын технологи хөтөлбөрт "Гагнуурын технологи инженер" мэргэшил чиглэл нээх гэдэг саналаар хэлэлцүүлэв. БШУ-ы Сайдын 2022 оны А/160 тушаалд индекс байхгүй, хөтөлбөрт мэргэших чиглэл хэрэгжүүлэх шийдвэр хэрхэн гарахаас хамаарч шийдвэрлэхээр болов.
4.	ШУТИС-ийн хөтөлбөрүүдэд S.FL111, S.FL112- Герман хэл 1, 2 /Сонгон хичээл/-ийг нэмж оруулах асуудлыг дахин хэлэлцүүлэх, /асуулт, санал/	Япон хэл дээр бичгийн түвшний агуулга тохирохгүй байна. Ашиглах сурах бичгийг тодорхой болгох Герман хэлний хичээлийн хөтөлбөрт 2 түвшний ялгааг гаргах Хичээлийн хөтөлбөр гэхээсээ илүүтэй гадаад хэлний хичээл, нэгдсэн шалгалт дээрээ анализ хийх Хичээлийн тодорхойлолтыг	Одоо хэрэгжүүлж буй гадаад хэлний хичээл, нэгдсэн шалгалт дээрээ анализ хийж, үр дүнг харгалзан цогц хэлбэрээр нэгдсэн бодлого боловсруулж, суралцагчийн англи хэлний түвшинг В1 хүргэх шаардлагын санал боловсруулан, дахин хэлэлцүүлэхээр буцаав.
5.	ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт Япон хэл 2 /N4/, Солонгос хэл 2, Хятад хэл 2 хичээлийг судлах боломжийг хангах асуудал, /асуулт, санал/		

		суралцахуйн үр дүнтэй уялдуулах Сургалтын бусад хэлбэрийг судлах	
6.	ХЕХ-ны 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улиралд хийх ажлын төлөвлөгөө батлах, /асуулт, санал/	Англи хэл дээр хэрэгжүүлэх хөтөлбөрийг эхлүүлэх гэдгээр тусгах Хөтөлбөрийн шинэчлэл дээр Коосэн 3 хөтөлбөр нэмэх	ХЕХ-ны 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улиралд хийх ажлын төлөвлөгөөг гишүүдийн саналыг тусган батлахыг дэмжлээ.
7.	ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл а) Сургалтын хөтөлбөр боловсруулах жишиг загвар /бакалавр, магистр, доктор/ б) Хичээлийн хөтөлбөрийн жишиг загвар /ГУУС, МХТС санал/ с) Сургалтын хөтөлбөрийн журам боловсруулах асуудал, үндсэн зарчим танилцуулах /асуулт, санал/	а) УМСистем хэсгийг нэмж оруулах Хичээлийн агуулгын давхардал, кодлолтын асуудлыг хамт шийдвэрлэх б) Оюутны бие даалтын цагийг хатуу тавих нь тохиромжгүй байна.	а) Сургалтын хөтөлбөр боловсруулах жишиг загварын саналыг дэмжсэн б) МХТС-ийн боловсруулсан хичээлийн хөтөлбөрийн жишиг загвараар хэрэгжүүлэх саналыг дэмжлээ с) Сургалтын хөтөлбөрийн журмын боловсруулалт дээр бүлэг бүрээр гишүүдийг хуваарилан ажиллуулахаар (Сургалтын хөтөлбөр боловсруулах журмын эхний хувилбар 2 сарын 20-ны дотор гарах) шийдвэрлэв.

Танилцсан:

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



Н.Эрдэнэхүү
/ХЕХ-ны дарга/

Г.Ариунтөгс
/ХЕХ-ны гишүүн/